

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Өвгөн	Дугаар	L332
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Мандалговь
Төрсөн газар	Адаацаг сум	Төрсөн он	1914
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хорийн жас	Сүм хийдийн дугаар	ДУАЦ 028
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 10	Ярилцлага авсан хүн	Жужа



Дундговь аймгийн Адаацаг сумын Хорийн жас, шинэ Дашчойнхорлин хийд

Жужа: Хорийн жас хэдэн лам, хэдэн дугантай байсан бэ?
 өвгөн: Дөрвөн дугантай байсан. Сахиусын дуган, хайлангийн дуган, баруун дуган, дүйнхор дугантай байсан. Дөрвөн суваргатай байсан. Тусгай ухаандаа галын байшин гэж байдаг шүү дээ.
 Энхбаяр: Галын байшин гэж олон байсан уу?
 өвгөн: Галын байшин хоёр байсан.
 Жужа: Ер нь модон дуганууд байсан уу, тоосгон дуганууд байсан уу?
 Өвгөн: Хайлангийн дуган, их дуган хоёр бол модон дуган байсан. Нөгөө хоёр нь шавар дуган байсан.
 Энхбаяр: Та энд их дуган байсан, энд хайлангийн дуган байсан, энд суварга, энд галын байшин байсан гээд будүүвч зураг хийж өгч чадах уу?
 Өвгөн: Их дуган энд, хайлангийн дуган баруун өмнөө, сахиусан дуган энд, чанх хойно сахиусан дуган, суварга нь сахиусан дуганы баруун талд, энд. Их жас гэж нэг том өргөө, мундаг том гэр энэ баруунтаа нь байсан.
 Жужа: Хамба ламын гэр хаана байсан бэ?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өвгөн: Үгүй, үгүй.
 Энхбаяр: Хятадууд байсан уу?
 Өвгөн: Байсан. Гэхдээ шохой шатааж, шавар зуурдаг цөөхөн хятадууд л байсан.
 Жужа: Хорийн жасын хажуугаар рашаан ус, худга булаг гэж бий юу?
 Өвгөн: Энэ Хорийн ил ус гэж сайхан задгай ус бий. Тэр баруун хойно нь Хадан усны рашаан гэж элэгний рашаан байдаг.
 Жужа: Хамбаас өөр гавж цолтой хүн байсан уу?
 Өвгөн: Өөр байхгүй байсан. Манай гавж багш л Богдын сунтагтай гавж гэж ирж байсан.
 Жужа: Хуучин ямар хошуу байсан юм бол?
 Өвгөн: Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошуу гэж байсан.
 Энхбаяр: Хийд хэдэн онд хаагдсан бэ?
 Өвгөн: 1937, 1938 оны үед хаагдсан. Би яг хаагдахад нь байгаагүй. би баруун хүрээнд очиж суух гээд 18-тай очиход хурал хаачихсан байсан.
 Энхбаяр: Өвөрхангайд байдаг баруун хүрээ юу?
 Өвгөн: Тийм, тийм.
 Жужа: Та хэдэн онд төрсөн, ямар жилтэй вэ?
 Өвгөн: Би 1920 онд төрсөн, тахиатай. Одоо 87 настай.
 Жужа: Та Дэлгэрийн Чойрын хийдийн тухай жаахан ярьж өгөөч?
 өвгөн: Өө би сайн мэдэхгүй. За тэр Заваа багш гэдэг чинь мундаг хүн, мундаг хүн. Таван аймалтай, 2 том дацантай. Голын аймаг, баруун аймаг, баруун хойд аймаг, зүүн аймаг, зүүн хойд аймаг гээд таван аймалтай. Тэр Заваа багш чинь мундаг хүн. Түүхийг нь мэднэ биз дээ, монголын ШУХ-ийн ууган гишүүн тийм хүн байсан. Монголын түүх шаштын хоёр том номтой, Заваа багшид мэдэхгүй юм байхгүй тийм мундаг хүн.
 Энхбаяр: Та хүүхэд байхдаа Зуутын хийд дээр очсон уу?
 Өвгөн: Нэг л удаа очсон. Тэнд чинь харин цам гардаг байсан юм. Олон дугантай их том хийд байсан. Манай энэ хөгшний ах багадаа цамд гардаг байсан юм гэнэ лээ. Тэнд хоёр дуган барьсан, цамын олон баг, хэрэгсэл чимэг зүүлт хийж өгсөн уран хүн байсан юм гэнэ лээ.
 Жужа: Одоо Хорин жасд сууж байсан өөр лам бий юу?
 Өвгөн: Хорин жасд сууж байсан уу, өө тийм надтай сууж байсан өөр хүн байхгүй.
 Жужа: Энэ сумын төвийн хийдийг анх сэргээхэд та байсан уу?
 Өвгөн: Харин би энэ сумын төвийн хийдийг анх сэргээсэн хүний нэг дээ. 1991 онд Чойрын хамбаанд ирж майдар эргэх ёслол хийсэн юм. Тэгээд 1992 онд би өөрөө энэ хийдийг байгуулахаар гэж санаачлан бодож боловсруулаад тэр үеийн нэгдлийн даргаас хурал хураах сав гүйсанд надад хоёр айлын орон сууц гарган өгч би тэнд лам нараа цуглуулан хурал хурж эхэлсэн, анх дөрвөн өвгөн ламтай тавуулаа хурж эхэлсэн. Тэгээд би мөнгөгүй хүн. Гэхдээ яахав, ард олны хишиг буан дэмээр дуган барилж эхлээд 1995 онд энэ дуганыг

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өвгөн: Чанх хойно хоёр давхар жижиг байшин байсан./ Самган нь ярианд оролцож саяхан болтол энэ хойно хоёр давхар байшин байсан, тэр мөн үү гэв /
 Өвгөн: Тэр мөн мөн. Хамба ламынх тэнд байсан.
 Жужа: Хамба ламын нэр нь хэн гэж байсан бэ?
 Өвгөн: Аа манай хамба ламын нэр нь би ч гавж багшаа гэсээр байгаад мартах нь. За бай... Дамбадаржаа гэдэг байсан. Дамбадаржаа гэж гавж хүн байсан.
 Жужа: Тойроод хэрмэн хашаа байсан уу?
 Өвгөн: Тэр үед хэрмэн хашаа байгаагүй. Дандаа задгай байсан.
 Жужа: Ямар овоог тахиж байв?
 Өвгөн: Манай Хорийн хийдийн хойд талд гурван овоо байсан юм. Хамгийн зүүн талд Самбарт, голынх нь Тахилгат, баруун талынх нь Бор овоо гэж байсан. Энэ гурван овоог тахидаг байсан. Манай голын овоо бол яг хэвээрээ, нураагаагүй одоо ч шүншигтэй хэвээрээ. Тэрийг тахидаг заавал бороо орох гээд л байдаг юм даа. Одоо ч тахидаг, энэ жил арай тахиагүй байна.
 Энхбаяр: Бааюу байсан уу?
 Өвгөн: Хийдийн бааюу гэж тэр зүүн өмнөө байсан.
 Энхбаяр: Цам байсан уу?
 Өвгөн: Цам гаргаж байгаагүй. Сор залдаг байсан. Жил бүр хайлан хийнэ. Нүгнээ хийнэ. Майдар эргэдэггүй. Хайланг дөчин тав хоног хурна.
 Энхбаяр: Хэд орчим ламтай байсан бэ?
 Өвгөн: Зуу гаруй ламтай байсан.
 Энхбаяр: Анх хэдэн онд байгуулагдсан юм бол, энэ Хорийн хийд?
 Өвгөн: Аа мэдэхгүй.
 Энхбаяр: Багцаа байна уу, таньд?
 Өвгөн: Мэдэхгүй, Зуут, Тавин, Хорийн хийд гэж ах дүү гурван хийд л гэдэг юм билээ.
 Энхбаяр: Энэ Хорийн хийд гэдгийн нэрийн утга учрыг мэдэх үү?
 Өвгөн: Нэрийн тухайд гэвэл анх Зуутын хийд зүүн ламтай, Тавин ламын хийд тавин ламтай, Хорийн хийд хорин ламтай байгуулагдсан гэж ярьж чаах юм билээ. Үүнээс л гарсан нэр болов уу.
 Жужа: Хийдийн гол сахиус юу байсан бэ?
 Өвгөн: Жамсран сахиустай байсан.
 Жужа: Зоч лам гэж байсан уу?
 Өвгөн: Дэндэвадш гэж нэг лүйжин тавьдаг тусгай лам байсан. Зоч лам бол нэг хоёроос илүү байгаагүй. Тусдаа дуган энэ тэр бол байгаагүй. хүний өнгөрсний хойдох энэ тэрт л явдаг тийм л лам байсан. Энэ хавьд тусгай дуган мугантай зоч нар байгаагүй, Чойр дээр ч байгаагүй.
 Энхбаяр: Энэ хийдээр өртөө зам дайрдаг байсан үү?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ашиглалтанд оруулсан.Түүнээс хойш 2005 он хүртэл гэсгүйгээр нь ажиллаж цогчин дуганаас гадна скаладтай, гал зуухтай гадуураа хашаатай болгосон. Одоо нэг хорин дөрвө, таван лам хүрж байна. Уржнан би нас өндөр боллоо. Одоо та нар авч яв гээд гэсгүйгээр нэг хүнд өгч нэг залуугаар уназдыг нь томилоод ингээд гарсан. Уул нь Тавингийн хурлын чинь төвд нэр нь Дашчойнхорлин гэж байсан юм байна. Үүнийг уламжлаад энэ шинэ хийдээ Дашчойнхорлин гэж нэрлэсэн. Яахав, миний энийг үнэлж ноднин намайг төрөөс алтан гадаас одонгоор шагнасан юм.
 Энхбаяр: Та Шинэ шавийн хийдийн тухай мэдэх үү?
 Өвгөн: Өө би багадаа ганц нэг очиж л байсан сайн мэдэхгүй. Хоёр дугантай л байсан. Харин Шинэ шавийн жинхэнэ том лам уназд хоёр нь байсан юм шүү дээ. Намайг энэ хийдийг анх байгуулахад маш их юм зааж өгсөн. Хурал номыг ингэж хурна, тэгж хурна гээд л. Хоёр мундаг лам байсан. Их ламыг нь Лувсанбалдан гэж, уназдын ламыг нь Балжир гэж хоёулаа ерэн гурав, ерэн долоо хүрч таалал болсон.
 Энхбаяр: Таныг энэ хийдээ байгуулахад анхны хамба нь хэн байсан бэ?
 Базар: Тэр Лувсанбалдан гэж мундаг том лам хамба байсан. Бид багш л гэнэ. Ер нь хамба гэдэг чинь урд бол хийд болгон хамбатай байгаагүй юм ш дээ. Энэ хавьд Зуутын хийд л цоржтой байсан. Бусад нь дандаа ловон ламтай л байсан.
 Энхбаяр: Хуучин хийд хурлуудаас өвлөгдөж ирсэн бурхан сахиус бий юу?
 Базар: Тэр Чойрын хийдийн Гэмлэл гуай гэж нэг лам хүн байсан. Тэр хүн намайг хийд байгуулахад бурхан, хэнгэрэг, цан энэ тэр өгсөн. Хорийн хийдээс Жамсран бурхан өвлөгдөж ирсэн. Гэмлэл гуай надад их юм өгсөн дөө, их бүрээ, бишлүүр, мөнгөн суварга өгсөн. Эд нар нь одоо байдаг юм. Их бүрээ чинь 4 метрийн урттай том эд байдаг. Майдрын морь тэргийг би өөрөө ерэн хоёр онд хийж байсан юм.
 Энхбаяр: За одоо ингээд ерөнхийдөө болж байна даа. Баярлалаа, таньд.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон